



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/151

Эрдэнэт

### Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.1.5 “в”, 29.1.6 “л”, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 27, 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 09, 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт гарсан Коронавируст халдвар (Ковид-19)-ын зарим тохиолдлуудын эх үүсвэр нь тодорхойгүй, цаашид хүн амын дунд халдвар тархах эрсдэлтэй байгаа тул аймгийн хэмжээнд Улсын онцгой комиссын 2021 оны 10 дугаар хуралдаанаас гарсан чиглэлийн дагуу 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2.Батлагдсан тохиолдлуудын ойрын хавьтлуудыг тусгаарлан ажиглах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудлууд (дэн буудал хамаарах)-ын үндсэн зориулалтын ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс түр зогсоож, тусгаарлан ажиглах байраар хамтран ажиллах гэрээний үндсэн дээр ашиглах ажлыг зохион байгуулж халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо) болон зочид буудлын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3.Нийт байгууллага, аж ахуйн нэгжүүд аль болох хүмүүсийн бөөгнөрөл үүсгэхгүйгээр халдвар хамгааллын дэглэмийг баримтлан цахимаар ажиллаж, ажлын тусгай горимд шилжин, ажиллагсадаа коронавируст халдвар илрүүлэх шинжилгээнд өөрсдийн зардлаар бүрэн хамруулах зохион байгуулалт хийж, “гэр-ажил-гэр” гэсэн

D:(Zahiramj) A-4 doc

6121020722

зарчмыг баримтлан, тухайн байгууллагаас батлагдсан тохиолдлын ойрын болон дам хавьтлын хяналтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, байгууллагынхаа хэмжээнд халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр онцгой анхаарч ажиллахыг нийт байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад даалгасугай.

4.Коронавируст халдвар цаашид хүн амын дунд тархах эрсдэлтэй байгаа тул иргэн бүр онцгой анхаарч аль болох гэрээсээ гарахгүй байх, олон нийтийн газраар явахгүй байх, гэр-ажил-гэр гэсэн маршрутыг мөрдөн, амны хаалтыг байнга хэрэглэн, гараа тогтмол ариутган, халдвар хамгааллын дэглэмийг сахиж, хариуцлагатай байхыг аймгийн нийт иргэддээ уриалсугай.

5.Энэхүү захирамжийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүй дэмжлэгээр ханган, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТЖАРГАЛ